

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

НИЙСЛЭЛИЙН ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, 2021 ОНД ХУВЬЧЛАХ ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/32 дугаар тогтоолоор нийслэлийн өмчөөс 5 барилга байгууламж, нийслэлийн өмчийн оролцоотой 1 хуулийн этгээдийн нийслэлийн өмчлөлийн хувийг хувьчлахаар шийдвэрлэж, нийслэлийн төсөвт 68 363,3 сая төгрөг төвлөрүүлэхээр шийдвэрлэснийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/36 дугаар тогтоолоор 73 363,3 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсны дагуу хувьчлалын ажлыг зохион байгуулж ажиллаа.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/220 дугаар захирамжаар өмч хувьчлалын үйл ажиллагааны зардалд Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 733,6 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн ба зар сурталчилгаа, үнэлгээний ажлын төлбөрт шаардлагатай зардлуудыг зарцуулж, одоо 166,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа болно.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтаар тус тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хуулийн этгээд, эд хөрөнгийн хувьчлалын арга хэлбэрийг судалж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулахыг үүрэг болгосны дагуу хавсралтад заасан 2 барилгатай холбоотой асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.30-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 60 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Үүнд: Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, хуучнаар Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн 12320 м² талбайтай байрыг Иргэний хуулийн хуулийн 105 дугаар зүйлийн дагуу “Улаанбаатар радио” ХХК-д тэргүүн ээлжинд санал болгох, Багануур дүүргийн 2 дугаар хорооны хуучин барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлахаар хувьчлах,

Мөн нийслэлийн өмчөөс 2015-2018 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад орж батлагдсан байсан Хан-Уул дүүргийн 13-р хороо, Туул тосгоны Захирагчийн албаны 2 барилга, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын байр, Баянзүрх дүүргийн 9-р хорооны хуучин барилга, Цагдаагийн хэсгийн барилга гэсэн 4 барилгыг хувьчлалын жагсаалтаас хасах тухай асуудлыг хэлэлцүүлж, “Хувьчлалын жагсаалтаас хасах тухай” 59 дүгээр тогтоолоор тухайн асуудлыг шийдвэрлүүлсэн болно.

Нийслэлийн өмч хувьчлах комиссын хурлын талаар

Тайлант онд Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг нийт 5 удаа /2020.02.07, 2020.04.01, 2020.05.15, 2020.07.08, 2020.07.30/ зохион байгуулж, 43 асуудал хэлэлцүүлж, дараах шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаа. Үүнд:

- Шинээр хувьчлах тухай - 11,
- Өмчлөгчийн эрх олгох тухай - 7,
- Хувьчлалын тайлан батлах тухай - 6,
- Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах тухай - 4,
- Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай – 3
- Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын дүнг баталсан тухай -2,

2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хурал /12 асуудал хэлэлцүүлж, 9 тогтоол/

1. *Шинээр хувьчлах*

- Нийслэлийн Засаг захиргааны “Хангарьд” ордны барилга
- СБД-ийн 10-р хорооны халуун усны барилга
- БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтсийн Шархадны хэсгийн хуучин барилга
- СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
- “Монгол шуудан” ХК-ийн эзэмшиж буй байрын 2 дугаар хэсэг
- ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга

2. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*

- Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламж
- БГД-ийн 10-р хорооны хуучин барилга
- БЗД-ийн 9-р хорооны хуучин барилга

3. *Өмчлөгчийн эрх олгох тухай*

- СХД-ийн 20-р хорооны халуун усны барилга
- “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын эзэмшиж буй байр

4. *Хувьчлалын тайлан батлах тухай*

- ХУД-ийн Цагдаагийн түр саатуулах байрлаж байсан барилга

2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хурал /10 асуудал хэлэлцүүлж, 5 тогтоол/

1. *Шинээр хувьчлах*

- “Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
- “Монгол шуудан” ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр

2. *Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах*

- “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын Ахуйн үйлчилгээний төв

3. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*

- Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламж
- “Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь

4. *Хувьчлалын тайлан батлах тухай*

- СХД-ийн 20-р хорооны халуун усны барилга
- “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын эзэмшиж буй байр

5. *Танилцуулга /Хувьчлалын жагсаалтаас хасах тухай/*

- ХИХУГ-ын эзэмшиж буй байр
- СБД-ийн 9 дүгээр хорооны хуучин байр
- ХУД-ийн 13-р хороо, Захирагчийн ажлын албаны 2 барилга

2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурал /11 асуудал хэлэлцүүлж, 9 тогтоол/

1. *Танилцуулга*

- Нийслэлийн Засаг захиргааны “Хангарьд” ордны барилга
- “СХД-ийн 21-р хорооны агуулахын барилга

2. *Өмчлөгчийн эрх олгох тухай*

- “Монгол шуудан” ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
- ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга

3. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*

- Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламж
- “Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь
- БГД-ийн 10-р хорооны хуучин барилга

4. *Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах*

- “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ
- Багахангайн мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ

5. Шинээр хувьчлах

- 50-р дэлгүүрийн өргөтгөлийн барилга
- Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн байр

2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хурал /7 асуудал хэлэлцүүлж, 7 тогтоол/

1.Шинээр хувьчлах

- Багануур дүүргийн 2-р хорооны хуучин барилга

2.Өмчлөгчийн эрх олгох тухай

- Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блок
- “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2-р хэсэг
- Баянгол дүүргийн 10 дугаар хорооны хуучин барилга

3.Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах

- СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга

4. Хувьчлалын тайлан батлах тухай

- “Монгол шуудан” ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
- ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга

2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хурал /3 асуудал хэлэлцүүлж, 3 тогтоол/

1.Хувьчлалын тайлан батлах тухай

- “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2-р хэсэг

2.Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын дүн батлах тухай

- “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ
- Багахангайн мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ

“Нийслэлийн өмч хувьчлах комисс”-ын ажиллах журмын 2.3 дах заалтыг үндэслэн хуралдааны бус хэлбэрээр 2 тогтоолыг албажуулан хэрэгжүүлж ажилласан. Үүнд: НӨХК-ын 2020.06.29-ны өдрийн “Өмчлөгчийн эрх олгох тухай” тогтоолоор хуучнаар “Автобус 3” НӨҮГ-ын барилга байгууламжийн өмчлөх эрхийг шинэ өмчлөгч “Камдер” ХХК-д шилжүүлэн олгох тухай, 2020.10.08-ны өдрийн “Хувьчлалын тайлан батлах тухай” тогтоолоор хуучнаар “Автобус 3” НӨҮГ-ын барилга байгууламжийг хувьчилсан тухай тайланг баталсан болно.

Нээлттэй дуудлагын худалдааны талаар

Нийслэлийн өмчөөс хувьчлагдахаар жагсаалтад орсон давхардсан тоогоор 18 объектын нээлттэй дуудлагын худалдааны зарыг нийтэд 9 удаа зарласан болно.

Нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээг “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн” зэрэг өдөр тутмын сониноор нийтэд зарлаж, Өмчийн ашиглалт, удирдлагын газрын “Umch.ub.gov.mn” сайтад байршуулсан. Мөн томоохон барилга байгууламжууд дээр видео зар сурталчилгааг хийлгэн UBS, TV9, SBN, TM, OTV, NTV, C1 зэрэг телевизээр өдрийн 2-3 удаагийн давтамжтайгаар явуулах, Мобиком корпорацитай маркетингийн гэрээ байгуулан мессэж зарыг 9911, 9909 дугаарын хэрэглэгчидэд хүргэх зэрэг арга хэмжээ авч ажилласан болно.

1. Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр буюу Бизнес хөгжлийн төвийн барилгын дуудлагын худалдааг 2020.02.10-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан боловч оролцогчийн санал ирээгүй.
2. Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламжийн дуудлагын худалдааг 2020.03.17-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан боловч оролцогчийн санал ирээгүй.
3. СБД-ийн 16-р хороо, ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга болон БГД-ийн 10-р хорооны хуучин барилгын дуудлагын худалдааг 2020.04.23-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба Хан-Уул дүүргийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилгыг “Энэрэл нигүүсэл оюун билгийн төв” ТББ 62,4 сая төгрөгөөр хувьчилж авсан.
4. СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, “Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр болон “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийн дуудлагын худалдааг 2020.06.02-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба “Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийг иргэн С.Эрдэнэ 254,0 сая төгрөгөөр хувьчилж аваад байна.
5. Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламж, “Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь, БГД-ийн дүүргийн 10-р хорооны хуучин барилгын дуудлагын худалдааг 2020.06.03-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламжийг “Камдер” ХХК 20 020,0 сая төгрөгөөр, БГД-ийн дүүргийн 10-р хорооны хуучин барилгыг иргэн Х.Гантулга 15,2 сая төгрөгөөр тус тус хувьчилж авсан.
6. СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, “Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр, Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувийг хувьчлах дуудлагын худалдааг 2020.06.25-ны өдөр зохион байгуулахаар зарласан ба оролцогчийн санал ирээгүй.
7. СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, “Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байрыг хувьчлах дуудлагын худалдааг 2020.09.22-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилгыг иргэн Ц.Ундрах 35,0 сая төгрөгөөр хувьчилж авсан.
8. Нийслэлийн Засаг захиргааны “Хангарди” ордны барилгын нээлттэй дуудлагын худалдааг 2020.11.20-ны өдөр зохион байгуулахаар зарласан боловч нийслэлийн удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу дуудлагын худалдааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах зарыг өгсөн.
9. Одоо СБД-ийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших 50-р дэргүүлийн өргөтгөлийн барилгын нээлттэй дуудлагын худалдааг 2020.12.10-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарлаад байна.

Иргэний хуулийн 105-р зүйлийн дагуу тэргүүн ээлжинд санал болгон хувьчилсан байрууд

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.04.01-ний өдрийн 01, 02 дугаар тогтоолоор Шуудангийн 20, 26 дугаар салбарын байрлаж буй байрыг хувьчлах үнийг тогтоож, Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу түрээсээр эзэмшиж буй “Монгол шуудан” ХК-д тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу 2020.04.20 –ны өдрийн 3/844 дүгээр албан бичгээр “Монгол шуудан” ХК-д мэдэгдэл хүргүүлсний дагуу 2020.04.24-ны өдөр 20-р салбарын байрыг “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж, төлбөрөө бүрэн төлсөн тул Өмчлөгчийн эрхийг шилжүүлсэн. Харин 26-р салбарын байрыг худалдан авахаас татгалзсан тул тогтоолын дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлахаар нийтэд зарлаад байна.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.05.15-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн 1222 м² талбай бүхий байрыг Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу “Улаанбаатар радио” ХК-д тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу “Улаанбаатар радио” ХХК-д 2020.05.26-ны өдрийн 3/1108 дугаар албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд “Улаанбаатар радио” ХХК нь 2020.06.25-ны өдөр “Худалдах, худалдан авах гэрээ”-гээ байгуулж, төлбөр тооцоогоо бүрэн барагдуулсан тул Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.08-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Өмчлөгчийн эрхийг шилжүүлсэн байна.

Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын талаар

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.04.01-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын 8 хүний халуун ус бүхий үйлчилгээний төвийг хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын хуваарийг баталж, хувьчлах үнийг 189,1 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоолын дагуу уралдаант шалгаруулалтыг нийтэд зарласан боловч оролцох хүсэлт ирээгүй.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.05.15-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ыг, 23 дугаар тогтоолоор “Багахангай мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийн сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын хуваарийг баталж, хувьчлах үнийг тогтоосон. Тогтоолын дагуу 2020.05.20-ны өдөр тухайн үйлдвэрийн газруудыг хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг нийтэд зарласан ба “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ дээр 2 компани, “Багахангай мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ дээр 1 компани тус тус хүсэлт ирүүлсэн. НИТХТ-ийн 2019 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан уралдаант шалгаруулалтын журмын дагуу ирүүлсэн этгээдүүдийг хүсэлтийг хянан үзэх, гэрээний төслийг боловсруулах үүрэг бүхий Газрын даргын 2020 оны А/241, А/242 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд журмын дагуу үйл ажиллагаагаа явуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/983 дугаар захирамжаар байгуулагдсан “Багахангайн мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ын тендерт оролцогчдоос ирүүлсэн саналыг үнэлж, дүнг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг санал ирүүлсэн “Циркон геологи” ХХК-ийн тендерийг үнэлж, уралдаант шалгаруулалтад тэнцүүлсэн боловч Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.30-ны өдрийн хурлаар дүнг хэлэлцээд тавигдсан шаардлагыг бүрэн хангаагүй байна хэмээн үзэн, уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцож, дахин зарлахаар шийдвэрлэн уралдаант шалгаруулалтын хуваарийг шинэчлэн баталсан болно. Хуваарийн дагуу 2020.08.07-ны өдөр уралдаант шалгаруулалтыг нийтэд зарлан ба 2 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн боловч баталсан хуваарьт заасан хугацаанд тендерийн материалаа ирүүлээгүй тул уралдаант шалгаруулалт явагдаагүй.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/984 дүгээр захирамжаар байгуулагдсан “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын тендерт оролцогчдоос ирүүлсэн саналыг үнэлж, дүнг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг оролцохоор материалаа ирүүлсэн “Эс эс макс” ХХК-ийн саналыг шаардлага хангаагүй гэж дүгнэн дүгнэлтээ Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн ба Нийслэлийн Өмч хувьчлах комиссоос уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцох тухай тогтоолыг баталж, “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын талаар цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулж танилцуулахыг НӨАУГ-т даалгасан болно.

Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөний талаар:


Нийслэлийн төсөвт 2020.11.30-ны өдрийн байдлаар 71 273,4 сая төгрөг төвлөрүүлэхээс өнөөдрийн байдлаар 20 752,3 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 29,1% байна.

1. ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга – 41,7 сая төгрөг
2. “Монгол шуудан” ХК-ийн 20 дугаар салбарын байр – 76,6 сая төгрөг
3. “Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын 2 дугаар хэсэг – 254,6 сая төгрөг
4. Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламж 20 020,0 сая төгрөг
5. БГД-ийн 10-р хорооны хуучин барилга 15,2 сая төгрөг
6. Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блок – 308,3 сая төгрөг
7. СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга – 35,0 сая төгрөг

Нэг. ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга нь 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр явагдсан нээлттэй дуудлагын худалдаагаар “Энэрэл нигүүсэл оюун билгийн төв” ТББ ялагч болж тус байгууллагад хувьчлагсан.



Хоёр. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 3/845 дугаартай албан бичгээр мэдэгдэл хүргүүлсний дагуу “Монгол шуудан” ХК нь 20 дугаар салбарын эзэмшиж буй байрыг Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу Худалдах, худалдан авах гэрээ байгуулан хувьчилж авсан болно.



Гурав. “Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын 2 дугаар хэсэг нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн нээлттэй дуудлагын худалдаанд Монгол Улсын иргэн С.Эрдэнэ ялагч тус байрын өмчлөгч болсон.



Дөрөв. Нийслэлийн Засаг захигааны 5 дугаар байр буюу Иргэний танхимд 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулагдсан нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч “Камдер” ХХК нь ялагч болсон тул Хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламжийг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/982 захирамжаар хүлээлгэн өгсөн.

Тав. 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулагдсан нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч Монгол Улсын иргэн Г.Гантулга ялагч болсон тул Баянгол дүүргийн 10 дугаар хорооны хуучин барилгын өмчлөгч болсон.



Зургаа. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 3/1078 дугаартай албан бичгээр ас “Улаанбаатар радио” ХХК-д мэдэгдэл хүргүүлний дагуу Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн 1220 м2 талбай бүхий байрыг Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу хувьчилсан.

Долоо. Иргэний танихимд 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан нээлттэй дуудлагын худалдаанд Монгол Улсын иргэн Ц.Ундрах ялагч болж Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн хуучин барилгыг хувьчилж авсан.



Бусад ажлын талаар:

“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн нийслэлийн өмчлөлийн 49,0%-ийг хувьчлах үнийг тогтоохоор зөвлөх үйлчилгээний тендерийн 2020.05.26-ны өдөр зарлаж 06.03-ны өдөр нээсэн, 7 компани санал ирүүлсэн боловч амжилтгүй, дараа нь 2020.06.30-нд зарлаж 2020.07.17-нд нээсэн, 4 компани санал ирүүлсэн боловч амжилтгүй, дараа нь 2020.10.19-нд дахин зарлаж 2020.10.29-нд нээсэн ба 5 компани саналаа ирүүлсэн. Үнэлгээний хорооноос

хураангуй жагсаалтыг гаргаж, компаниудад урилгаа хүргүүлсэн ба тендерийг 2020.12.10-нд нээж үнэлгээг нээнэ.

Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлах дараах барилга байгууламжийн үнэлгээг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж тайланг хүлээн аваад байна.

№	Хуулийн этгээд эд, хөрөнгийн нэр	Үнэлгээ хийсэн компанийн нэр	Үнэлгээний дүн	Гэрээний дугаар
1	50-р дэлгүүрийн өргөтгөлийн барилга	“Үнэлгээ консалтинг” ХХК	2 339 429 000	02/2019
2	Баянгол дүүргийн 8 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	“Золоч” ХХК	Үнэлгээ хийгдэж байна.	03/2019
3	Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга		Үнэлгээ хийгдэж байна.	
4	Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр		84 084 900	
5	Монгол шуудан” ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр		76 559 700	
6	Баруун сэлбэ үйлчилгээний төв” ХХК	“Үнэлгээ консалтинг” ХХК	1 590 000 000	01/2020
7	“Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь	“Эрдэнэс экаунтинг энд консалтинг” ХХК	564 400 000	01/2019
8	“Ану сервис” ХХК-ийн менежментийн гэрээгээр ажиллуулж буй 8 зуухны барилга байгууламж	“Профешнл коннекшн” ХХК	1 072 000 000	10/2020
9	СБД”ийн ЗДТГ-ын өргөтгөлийн барилга	“Ю би пропертиз” ХХК	3 262 580 000	09/2020

ШИНЭЭР ХУВЬЧЛАХ ЭД ХӨРӨНГИЙН ТАЛААР

Нийслэлийн өмчөөс 2021 онд шинээр 9 барилга байгууламжийг хувьчлах тухай Барилга байгууламжийн жагсаалт:

№	Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн нэр, байршил	Байршил	Хувьчлалын арга хэлбэр
---	---	---------	------------------------

1	Хар үнэгний аж ахуйн барилга байгууламж	ХУД-ийн 3-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
2	Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	БЗД-ийн 12-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
3	“Монгол шуудан” ХК-ийн 46-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр	СБД-ийн 6-р хороо	Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу санал болгон хувьчлах
4	“Монгол шуудан” ХК-ийн 44-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр	СБД-ийн 4-р хороо	Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу санал болгон хувьчлах
5	“Монгол шуудан” ХК-ийн 21-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр	СХД-ийн 17-р хороо	Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу санал болгон хувьчлах
6	Халуун усны барилга	СБД-ийн 15-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
7	Халуун усны барилга	СБД-ийн 16-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
8	Халуун усны барилга	СБД-ийн 18-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
9	Халуун усны барилга	ХУД-ийн 16-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа

1. Хар үнэгний аж ахуйн барилга байгууламж



Хар үнэгний аж ахуйн барилга байгууламж нь Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Туул тосгоны Салхитын аманд 1988 оноос эхлэн баригдаж 1994 онд ашиглалтад орсон боловч зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаараа ашиглагдаагүй өнөөдрийг хүрсэн.

Тус барилга байгууламжууд нь Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй байсан ба НИТХТ-ийн 2013 оны 50 дугаар тогтоолоор Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансад шилжин ирсэн, эзэмшил газрын хэмжээ 20,5 га болно.

Хар үнэгний аж ахуйн барилгууд нь бетон суурьтай, тоосгон ханатай, төмөр бетон хавтан хучилттай ба халаалт нь бие даасан байдлаар халаах уурын зуухтай баригдсан. Гэвч ашиглалтгүй олон жил болсноос барилга байгууламжууд нь биет элэгдэлд орж, өнөөдрийн байдлаар ашиглах боломжгүй болоод байна.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар 2013 оноос эхлэн харуул хамгаалалт гарган, сахиул ажиллуулж байгаа бөгөөд цалингийн зардалд жилд 6309,5 мянган төгрөгийн зардал гаргадаг.

2.Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга

Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга нь Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр, Жанжин клубын дэргэд байрлалтай, 2000 онд өрхийн эмнэлгийн зориулалтаар баригдаж ашиглалтанд орсон.

Барилга нь цутгамал бетон суурьтай, тоосгон ханатай, модон шувуу нуруу бүхий хар цаасан дээвэртэй, 6 өрөө тасалгаатай, нийт 111,8 м² талбайтай, нам даралтын зуухаар халдаг, бохирын цооногтой, зөөврийн усан хангамжтай, дан барилга бөгөөд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансанд бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 24,400,000 төгрөг, 554 м² эзэмшил газартай.

Тус барилгад Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаад 2013 онд Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга баригдаж ашиглалтанд орсноор суларч, одоогоор ашиглалтгүй байна.



3.Шуудангийн 46 дугаар салбарын түрээсээр эзэмшиж буй байр




“Монгол шуудан” ХК-ийн шуудангийн 46 дугаар салбар нь Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж, Бага тойруугийн 1 дүгээр байрны 1 давхарт байрладаг, уг барилга нь 1960 онд ашиглалтад орсон бөгөөд тэр цагаас хойш шуудангийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа болно.

Талбайн хэмжээ 110,4 м², Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансанд бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 77,875,601 төгрөг.

4. Шуудангийн 44 дүгээр салбарын түрээсээр эзэмшиж буй байр

“Монгол шуудан” ХК-ийн шуудангийн 44 дүгээр салбар нь Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 50 мянгатын 20 дугаар байрны 1 давхарт байрладаг, уг барилга нь 1965 онд ашиглалтад орсон бөгөөд тэр цагаас хойш шуудангийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа болно.

Талбайн хэмжээ 66,7 м², Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансанд бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 47,049,842 төгрөг.



5. Шуудангийн 21 дүгээр салбарын түрээсээр эзэмшиж буй байр



“Монгол шуудан” ХК-ийн шуудангийн 21 дүгээр салбар нь Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, Москвагийн гудамж, 1 дүгээр хорооллын “Пирамид” үйлчилгээний төвд байрладаг, уг барилга нь 1985 онд ашиглалтад орсон бөгөөд тэр цагаас хойш шуудангийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа болно.

Талбайн хэмжээ 167,5 м², Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансанд бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 105,149,506 төгрөг.

Монгол Улсын Их Хурлын 1999 оны “Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” 29 дүгээр тогтоолоор шуудангийн салбаруудын үйл ажиллагаа явуулж буй эдгээр байрууд нь Орон сууц, нийтийн аж ахуйн конторуудын балансад бүртгэлтэйгээр нийслэлийн өмчид шилжиж ирсэн.

Монгол Улсын Их хурлын 2003 оны “Шуудангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2006 оны 195 дугаар тогтоолд Шуудангийн үйлчилгээний шуурхай, найдвартай байдлыг хангахын тулд аймаг, нийслэл, сумын төвүүдэд шуудангийн үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа байрыг Монгол шуудан компанийн эзэмшилд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхээр заасан байна.

Энэ заалтыг үндэслэн “Монгол шуудан” ХК-иас нийслэлд үйлчилгээ явуулж буй шуудангийн байруудыг шилжүүлэн авах хүсэлтийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт удаа дараа тавьж байсан. Үүний дагуу нийслэлийн өмчид бүртгэлтэй тус байруудыг үнэ төлбөргүйгээр төрийн өмчийн оролцоотой “Монгол шуудан” ХК-д шилжүүлэн өгөх боломжгүй, харин хувьчлах тохиолдолд тэргүүн ээлжинд санал болгох боломжтой гэсэн хариуг хүргүүлж байсан байна.

“Монгол шуудан” ХК нь эдгээр байруудыг баригдсан цагаас нь эхлэн хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байгаа тул Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн 105.1 дэх хэсэгт “Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг арав буюу түүнээс дээш жилийн турш хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байсан эзэмшигч уг эд хөрөнгийг өмчлөх эрхийг тэргүүн ээлжинд олж авах давуу эрхтэй байна” гэж заасны дагуу тус компанид санал болгон хувьчлах саналтай байна.

6. Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны халуун усны барилга



Халуун усны барилга нь Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэр, Дамбадаржаа, Шадивлангийн авто замын баруун талд байрлалтай бөгөөд 2015 онд тус дүүргийн гэр хорооллын оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай халуун усны газар болон бусад ахуйн үйлчилгээний үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдаж ашиглалтад орсон. Барилга нь цутгамал бетон суурьтай, тоосгон ханатай, төмөр бетон хучилттай, хар цаасан дээвэртэй, 319,9 м² талбайтай, 2 давхар, гүний худагтай, нам даралтын зуухаар халдаг, бохирын цооногтой. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 193 380 634 төгрөг, 409 м² эзэмшил газартай.

Халуун усны барилга нь цэвдэгтэй газар баригдсан учраас суулт өгч, цууралт үүссэн, худгийн ус нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй зэрэг шалтгааны улмаас ашиглалтад орсоноосоо хойш ажиллаагүй байна.

7. Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны халуун усны барилга



Халуун усны барилга нь Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгын дэргэд байрлалтай бөгөөд 2005 онд тус дүүргийн гэр хорооллын оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай халуун ус, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдаж ашиглалтад орсон.

Барилга нь цутгамал бетон суурьтай, тоосгон ханатай, төмөр бетон хучилттай, төмөр дээвэртэй, 138,6 м² талбайтай, дан барилга ба гүний худагтай, нам даралтын зуухаар халдаг, бохирын цооногтой. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 29,700,000 төгрөг, эзэмшил газрыг нь баталгаажуулаагүй байна.

Өнөөдрийн байдлаар ашиглалтгүй байгаа бөгөөд 2018 онд гүний худаг нь усгүй болж үйл ажиллагаа нь зогссон байна. Тухайн байршилд хувийн халуун усны газрууд шинээр олноор нээгдсэн байна.

8. Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны халуун усны барилга



Халуун усны барилга нь Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэр, 71 дүгээр сургуулийн хойно байрладаг бөгөөд 2015 онд гэр хорооллын оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай халуун усны газар болон бусад ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдаж ашиглалтад орсон. Барилга нь цутгамал бетон суурьтай, тоосгон ханатай, төмөр бетон хучилттай, хар цаасан дээвэртэй, 245,5 м² талбайтай, 2 давхар, гүний худагтай, нам даралтын зуухаар халдаг, бохирын цооногтой. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 92,700,000 төгрөг, 200 м² эзэмшил газартай.

Халуун усны барилга нь Хороо, ерхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгын дэргэд баригдсан ба худгийн ус нь эрүүл ахуйн шаардлага хангадаггүй шалтгааны улмаас ашиглалтад орсоноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

9. Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны халуун усны барилга



Халуун усны барилга нь Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр, “Буянт-Ухаа цогцолбор” сургуулийн урд талд байрладаг, 2012 онд гэр хорооллын оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай халуун усны газар болон бусад ахуйн үйлчилгээний үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдаж ашиглалтад орсон. Барилга нь цутгамал бетон суурьтай, тоосгон ханатай, төмөр бетон хучилттай, хар цаасан дээвэртэй, 357 м² талбайтай, 2 давхар, зөөврийн устай, нам даралтын зуухаар халдаг, бохирын цооногтой. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, бүртгэлийн үнэ 180,900,000 төгрөг, эзэмшил газар нь баталгаажаагүй байна.

Тус хорооны гэр хороолол барилгажсан тул 2018 оноос халуун усны газрын үйл ажиллагаа нь зогссон.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР